

Хутганы Тухай Сургуулийн Журам

Хүндэт эцэг эх болон асран хамгаалагч танаа

NSW мужийн засгийн газар Хутганы Тухай Сургуулийн Журмыг дахин боловсруулах зорилгоор саяхан Сих (Sikh) гаралтай иргэдийн төлөөлөгчид болон эрүүл мэнд, аюулгүй байдлын мэргэжилтнүүдтэй хамтран олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Яамны зүгээс энэхүү хэлэлцүүлэгт өөрсдийн санал бодлоо хуваалцсан бүх гишүүд мөн удирдамжийг дахин боловсруулахад тусалсан хүмүүст талархлаа илэрхийлж байна. Уг удирдамжинд сурагч сургууль дээр хутга авчирч болох тохиолдлуудыг тусгаж оруулсан юм.

Эдгээр удирдамжууд нь тус яам сурагчид болон ажилтнуудын эрүүл мэнд болон аюулгүй байдалд тулгарч болох болзошгүй эрсдлээс тэднийг хамгаалахад боломжит бүх арга хэмжээг авах мөн NSW мужийн ялгаатай нийгмийн бүлгийг хүндэтгэн, аливаа хууль бус ялгаварлан гадуурхлаас зайлсхийх үүрэг хариуцлагаа биелүүлж байгаагийн илрэл юм.

Сургууль дээр хутга авчрах хориотой хэвээр байх боловч шинэ, хатуу удирдамжийг мөрдөн биелүүлж байгаа нөхцөлд л сурагчийг биедээ Кирпан авч явахыг нь зөвшөөрөх болно. Кирпан гэдэг нь адис хүртсэн Сих (Sikh) гаралтай Sikh шашинтай хүмүүсийн биедээ авч явдаг хутгатай төстэй эд зүйл бөгөөд энэ нь тэдний хувьд итгэл үнэмшлээ илэрхийлэх шашны чухал ач холбогдолтой юм.

Адис хүртсэн Сих шашинтай сурагч сургууль дээр Кирпан авчрах зөвшөөрөл авахын тулд тухайн Кирпан нь:

- жижиг хэмжээтэй буюу нийт урт нь 16.5см (ойролцоогоор 6.5 инч) эсвэл үүнээс бага хэмжээтэй мөн хурц үзүүр эсвэл өнцөггүй байх
- ир нь бүрээсээр хучигдсан байх бөгөөд суларч унахааргүй байх
- хувцасны дотуур биедээ авч явах ба ашиглахгүй байхаар сайн бэхлэгдсэн байх
- биеийн тамир, спортын арга хэмжээнд оролцохдоо тайлж, аюулгүй газар хадгалах эсвэл “биедээ сайн бэхлэх”.

Анхаарах зүйл: “биедээ сайн бэхлэх” гэдэг нь бат бөх даавуугаар ороох, спорт боолт эсвэл арьсан бүсээр хамгаалах буюу суларч унан өөрийгөө болон бусдыг гэмтээхээргүй болгон бэхлэхийг хэлнэ.

Асууж шалгасан үед тухайн сурагч эдгээр удирдамжуудыг мөрдсөн эсэхээ харуулах ёстой. Аюулгүй байдалтай холбоотой аливаа асуудлыг тухайн сурагч болон эцэг эх эсвэл асран хамгаалагчтай нь ярилцана.

Адис хүртсэн Сих шашинтай сурагчид сургууль дээр Кирпан авчирч болох ч тэд үүнийг сургууль дээр ямар нэгэн зорилгоор ашиглахыг хориглоно.

Сургалтын зорилгоор хутга ашиглахаас (тухайлбал хоолны технологи дадлагын хичээлийн үеэр) бусад ямар ч тохиолдолд сурагчид сургууль дээр хутга авчрахыг хориглоно.

Хичээлээ тараад шууд TAFE-н хичээлд орох сурагчид сургууль дээр хутга авчрах тохиолдолд хичээл эхлэхээс өмнө хутгаа хайрцагтай нь эсвэл бүрээстэй нь сургуулийн оффист хүлээлгэн өгч, хичээл тарсны дараа авах ёстой.

Шинэ удирдамжуудын тухай нэмэлт дэлгэрэнгүй мэдээллийг дараах вэб хуудсаар авна уу <https://education.nsw.gov.au/about-us/rights-and-accountability/legal-issues-bulletins/knives-in-schools>

Хүндэтгэсэн

Захирал (Principal)

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл мөн танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээ болох 131 450 руу залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй. Операторт холбогдохыг хүссэн дугаараа хэлэх ба оператор тухайн шугамд таны яриаг орчуулах орчуулагчийг холбох болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.